

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ БА УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УЯЛДААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

УДИРТГАЛ

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийг Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдөр УИХ-д өргөн барьсан билээ. Энэхүү товч судалгаагаар “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжууд (2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралт) нь 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдөр УИХ-аар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд туссан төсөл, арга хэмжээтэй хэрхэн уялдсанд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуульд зааснаар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг **тухайн жилд хэрэгжүүлэх төсөв**, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан **төсөл**, **арга хэмжээ** бүхий төлөвлөлтийн баримт бичиг юм. Уг баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд санхүүжилтийн эх үүсвэрийг нь тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх шаардлагыг хангасан байх ёстой. Нөгөө талаас мөн хуульд зааснаар улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай. Түүнчлэн Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсан УИХ-ын тогтоолын 2.1-т “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах”-ыг Засгийн газарт даалгажээ. Тиймээс улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлт нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээтэй нийцтэй байх ёстой болж байгаа юм.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг олон төрлийн эх үүсвэрээс нийтдээ 13.4 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 8 тэргүүлэх чиглэлийн 184 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн

байна. Уг төлөвлөгөөний гол зорилго нь өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа бөгөөд “Экспортыг нэмэгдүүлнэ”, “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ”, “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна”, “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг

сайжруулна”, “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна”, “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна”, “Ногоон хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” гэсэн 8 бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлжээ.

Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ)-ийн эрхлэх асуудлын хүрээнд хүрэх 21 үр дүн, хөтөлбөрийн 41 үр дүнтэй холбоо бүхий 2.8 их наяд төгрөгийн санхүүжилттэй 116 төсөл, арга хэмжээ тусгагдсан байна. Тэдгээрийн 65 нь буюу 56.03 хувь нь хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээ байна.


Уг төлөвлөгөөнд өмнөх жилүүдэд эхэлсэн буюу бүр 2019 онд эхэлсэн төсөл, арга хэмжээг тусгасан байгаа нь уг төсөл, арга хэмжээ

2024 онд хэрэгжиж эхлэх мэтээр олон нийтэд ойлгогдох эрсдэлтэй байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд зөвхөн тухайн жилд шинээр эхлэх төсөл, арга хэмжээг тусгаж, улмаар хэрэгжүүлэх хугацааг тодорхой заадаг болох нь олон нийтийг төөрөгдүүлэхээс сэргийлэхийн дээр тус төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа дуусаж буй эсэхийг хянахад ач холбогдолтой юм. Мөн бодлого боловсруулагчид өнгөрсөн хугацаанд эхэлсэн, хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдийг биш зөвхөн тухайн жилд шинээр эхлэх хөгжлийн төсөл, арга хэмжээг анхааралтай хэлэлцсэнээр хөгжлийн жилийн төлөвлөгөө илүү чамбай боловсруулагдах нөхцөл бүрдэнэ гэж судлаачийн зүгээс үзэж байна.


МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9.4 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 3.2 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 1,050 төсөл, арга хэмжээ тусгагдсан. Үүний 498 нь буюу 47.4 хувь нь 2024 оноос шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ байна.



Шинээр эхлэх төсөл, арга хэмжээний 358 буюу 72.03 хувь нь барилга байгууламж, 18 нь буюу 3.6 хувь нь их засвар, 118 нь буюу 23.7 хувь нь тоног төхөөрөмж, 4 нь буюу 0.8 хувь нь техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) байгаа юм.

График 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц, 2024 он



Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ТӨСВИЙН УЯЛДАА

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын шинжтэй 63 төсөл, арга хэмжээнээс дөнгөж 36 нь буюу 57.1 хувь нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан байна (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү). 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдаагүй төслүүдээс дурдвал, “Хавдар судлалын үндэсний төвийн салбар II”-ын барилга барих (хуулийн дугаар: 3.3.2.3), хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх (хуулийн дугаар: 5.1.1.3) зэрэг байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслөөс харахад төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих 497 төсөл, арга хэмжээний 162 буюу ердөө 32.6 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд мөн туссан төсөл, арга хэмжээ байна.¹

ДҮГНЭЛТ, САНАЛ

Дээрх үр дүнд үндэслэн Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлт нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээтэй **уялдаа муутай байна** гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

2024 оны төсвийн хөрөнгө оруулалт болон Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөний тухайд дараах анхаарах асуудлууд байгаа бөгөөд тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн саналыг хамтатган дэвшүүлж байна. Үүнд:

1. **Тухайн жилийн Улсын хөгжлийн төлөвлөгөөнд өмнөх онуудад эхлүүлсэн төсөл, арга хэмжээг тусгах эсэхийг тодорхой болгох:** Олон улсын туршлагаас үзэхэд төлөвлөгөөнд өнгөрсөн хугацаанд эхэлсэн, хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдийг биш зөвхөн тухайн жилд шинээр эхлэх хөгжлийн төсөл, арга хэмжээг тусгаснаар бодлого боловсруулагчид тухайн оны хөгжлийн төлөвлөгөөг батлах үед анхааралтай хэлэлцэх боломжийг бүрдүүлж, улмаар баримт бичиг чамбай боловсруулагдах нөхцөл бүрддэг байна.

¹ 157 нь барилга байгууламж, 5 нь тоног төхөөрөмж

2. **Хөгжлийн төлөвлөгөөнд чухал төсөл, арга хэмжээний санхүүжилтийг заавал тооцож тусгах:** Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх (хуулийн дугаар 3.2.1.2), төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх (хуулийн дугаар 3.2.3.1) зэрэг чухал арга хэмжээний санхүүжилт тооцогдоогүй байгаа нь төлөвлөлт сул байгааг илтгэж байгаагаас гадна үр дүнг нь хэмжих боломжгүй болгож байна.
3. **Орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх боломжтой харьцангуй бага төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг улсын төсвөөр санхүүжүүлэхгүй байх:** Сум, дүүрэг, гэр хорооллын түвшинд хэрэгжих төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвөөр санхүүжүүлэх зарчим баримтлах хэрэгтэй байна. Тухайлбал XII.2.10 хуулийн дугаартай Гэр хорооллын ундны усны худгийн засвар (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэгт байршилтай, 100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй), XV.1.1.33 хуулийн дугаартай Аймгийн төвийн доторх хатуу хучилттай авто зам (Дархан-Уул, Дархан сум, 4, 5 дугаар баг, 4,986 сая төгрөгийн төсөвт өртөгтэй), XV.1.1.35 хуулийн дугаартай Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км (Дорнод, Хэрлэн сум, 3,900 сая төгрөгийн төсөвт өртөгтэй) гэх мэт.
4. **Үйл ажиллагаа нь тодорхойгүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхгүй байх:** Төсвийн төсөлд тусгагдсан орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд чухам юу хийх, ямар үр дүнд хүрэх зэрэг нь тодорхойгүй (хуулийн дугаар: XVI.3.9-XVI.3.20).
5. **Хөгжлийн төлөвлөгөөний дараах өндөр ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгагдаагүй байгаад анхаарч, төсвийн төсөлд нэмж тусгах замаар хөгжлийн төлөвлөгөө, улсын төсвийн уялдааг сайжруулах.** Үүнд:
- “Хавдар судлалын үндэсний төвийн салбар II”-ын барилга барих (хуулийн дугаар: 3.3.2.3)
 - Хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх (хуулийн дугаар: 5.1.1.3)
6. **Төсвийн төсөлд тусгагдсан ч Хөгжлийн төлөвлөгөөнд байхгүй дараах төсөл, арга хэмжээнд анхаарч, цаашид хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгахгүй байх.** Үүнд:
- Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл (хуулийн дугаар: XVII.1.33)
 - Дулааны станцын шинэчлэл (Ховд, Жаргалант сум) (хуулийн дугаар: XVII.1.35)
 - “Халдварт өвчин судлалын үндэсний төв-2”-ийн гадна инженерийн шугам, сүлжээ (Төв, Сэргэлэн сум) (хуулийн дугаар: XVIII.1.41)
 - Зүрх, судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээ (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо) (хуулийн дугаар: XVIII.1.44)
 - Наркологийн төв эмнэлгийн барилга (Баянхонгор, Баянхонгор сум) (хуулийн дугаар: XVIII.1.45)
 - Нийслэлийн хүүхдийн сэргээн засах «Эрүүл үрс» төвийн барилга, 80 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг) (хуулийн дугаар: XVIII.1.46).

² Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.13-т Улсын хөгжлийн төлөвлөгөө нь ... төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг гэж, 6.10.3-т улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх гэж тус тус заасан ч Улсын хөгжлийн төлөвлөгөө, улсын төсвийн уялдааг нарийвчлан тодорхойлсон эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь уг хоёр баримт бичгийн нийцэл, төсөл, арга хэмжээг давхардуулан агуулах эсэх зэргийг тодорхойгүй болгож байгаа юм.

7. **Улсын хөгжлийн төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээг ерөнхий байдлаар Төсвийн төсөлд нарийвчлан тусгадаг зохицуулалтыг бий болгох²:** Хөгжлийн төлөвлөгөөнд боловсрол болон нийтийн бие тамир, спортын салбартай холбоотой төсөл, арга хэмжээ Улсын хөгжлийн төлөвлөгөөнд сургууль, цэцэрлэг барих (3.1.4.1 ба 3.1.5.1 хуулийн дугаартай), Биеийн тамир спортын байгууламж, талбай, тоног төхөөрөмжөөр хангах (3.3.3.3 хуулийн дугаартай) гэсэн байдлаар ерөнхий буюу багц арга хэмжээ агуулах мэтээр тусгагдсан. Иймд төсвийн төсөлд

холбогдох төсөл, арга хэмжээг нарийвчлан тусгах боломжтой байхад эрүүл мэндийн салбарын төсөл, арга хэмжээ Улсын хөгжлийн төлөвлөгөөнд нарийвчилсан байдлаар буюу ямар эмнэлгийн барилгыг барих, үргэлжлүүлэх нь тодорхой тусгагдсан байгаа тул Төсвийн төсөлд тусгагдсан олон тооны эрүүл мэндийн төвийн барилга барих, өргөтгөх төсөл, арга хэмжээ нь Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй мэтээр харагдуулахад хүргэж, энэ нь баримт бичгүүдийн уялдааг муутгаж байгаа юм.

---oOo---

ХАВСРАЛТ 1

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УЛСЫН
ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД МОНГОЛ
УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН БАЙДАЛ

№	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	2024 оны улсын төсөвт туссан эсэх (тийм-1, үгүй-0)		
1	Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Олон улсын жишигт нийцсэн боомтын тоог нэмэгдүүлнэ.	Хилийн боомтуудад ухаалаг цахим гарц суурилуулах	0		
2	Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	Олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг малын халдварт өвчнийг бууруулна.	Мал эмнэлгийн оношилгооны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	0		
3	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	Эрдэнэбүрэн-гийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	0		
4			Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх	0		
5			10 аймгийн төвд баригдах дулааны станцын цахилгаан, ус хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх	1		
6			220/110/35 кВ-ын Багануур дэд станцыг 220 кВ-аар өргөтгөж, шинэчлэх	0		
7			Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	1		
8			Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндий дэх шинэ хотуудын цахилгаан хангамжийг шийдвэрлэх хүрээнд 220/110/35 кВ-ын "Сэргэлэн" дэд станц барьж, Сонгино дэд станцтай 768 км урт ЦДАШ холбох, 110 кВ-ын Аэросити дэд станц барих ажлыг үргэлжлүүлэх	1		
9			Шинэ нисэх-Зуунмод сумыг холбосон 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц байгуулах ажлыг үргэлжлүүлэх	1		
10			Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 МВт-аар өргөтгөх	1		
11			Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Монгол кино үйлдвэрийг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн төв болгох	0

№	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	2024 оны улсын төсөвт туссан эсэх (тийм-1, үгүй-0)
12			Байгалийн түүхийн музей (хуучнаар Лениний музей)-г шинэчлэн засварлах	1
13		Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори байгуулах	1
14			Улсын драмын эрдмийн театрын барилгын хүчитгэлийг хийж гүйцэтгэх	1
15	Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	Чөлөөт бүсүүдийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	Бүсийн болон аймаг, сумын доторх цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлыг үргэлжлүүлэх (Сэлэнгэ, Алтанбулаг)	1
16	Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих	1
17			Спорт заал барих	1
18			Дотуур байр барих	1
19			Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухааны лабораторийг тохижуулах	0
20			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх	1
21		Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ.	Цэцэрлэгийн барилга барих	1
22	Өвчлөл, нас баралтыг бууруулна.	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг үргэлжлүүлэх	0
23			"Хавдар судлалын үндэсний төвийн салбар II"-ын барилга барих	0
24			Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих	0
25			Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлэх	0
26	Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Улирлын чанартай "Буйр нуур" усан замын боомт байгуулах	0
27	Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлнэ.	Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай авто зам барих (Дорнод, Баян-Уул сум)	1

№	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	2024 оны улсын төсөвт туссан эсэх (тийм-1, үгүй-0)
28			Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто зам барих (Хэнтий, Норовлин сум, Дорнод, Баян-уул сум)	1
29			Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай 130 км авто замыг үргэлжлүүлэх (Хэнтий, Батноров, Норовлин сум)	1
30			Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн А0502 дугаартай 50 км авто замын их засвар хийх (Хэнтий)	0
31			Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам барих (Дорнод)	1
32			Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 31.08 км (Булган, Хишиг-Өндөр сум)	1
33			Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын төгсгөл 67.8 км	1
34			Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км (Архангай, Батцэнгэл сум)	1
35			Улаангом-Увс нуур чиглэлийн 25.84 км хатуу хучилттай авто зам барих (Увс аймаг)	1
36			Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	0
37			Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замд байрлах Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	0
38			Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын Хараа голын 85 у/м төмөр бетон гүүр барих	0
39			Төв аймгийн Тэрэлж БЦГ-ын (Горхи-0.66 км, Тэрэлж-1.4 км) давааны хатуу хучилттай авто зам барих	0
40			Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 271-298 км хооронд 27 км хатуу хучилттай авто замын их засвар шинэчлэл-тийг хийх	0
41			Архангай аймгийн Донгойн давааг 2.5 км хатуу хучилттай болгох авто зам барих	1

№	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	2024 оны улсын төсөвт туссан эсэх (тийм-1, үгүй-0)
42			Завхан аймгийн Солонготын давааг 11.66 км хатуу хучилттай болгох авто зам барих	0
43			Архангай аймгийн Цагаан давааг тойруулан Гурван даваагаар давуулан А0603 дугаартай улсын чанартай авто замтай холбох 32.5 км хатуу хучилттай авто зам барих	0
44			Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хорго, Тэрхийн цагаан нуур хүртэлх 13 км хатуу хучилттай авто зам барих	1
45			Балж голд төмөр бетон гүүр барих	0
46			Баруун-Урт- Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих (Сүхбаатар-Баруун-Урт, Сүхбаатар сум)	1
47			Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих	1
48			Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын төслийн бэлэн байдлыг хангах	0
49			Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам барих 32.4 км	1
50	Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлнэ.	Хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх	0
51	Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Цахилгаан болон хийн автобусаар парк шинэчлэлт хийх	1
52		Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно.	"Сэлбэ-Сэргэлт" төслийг хэрэгжүүлэх	0
53	Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Инженерийн бүрэн хангамжтай сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлнэ.	"Залуус-1" төслийн эхний ээлжийн барилга байгууламжийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний угсралтын ажлыг үргэлжлүүлэх	1

№	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	2024 оны улсын төсөвт туссан эсэх (тийм-1, үгүй-0)
54			“Ногоон нуур 1008” төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж, инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэх	0
55			“Солонго 1, 2” төслийн барилгын ажлыг эхлүүлэх	0
56		Гэр хорооллын инженерийн дэд бүтцийн хангамжийг сайжруулна.	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл хэрэгжүүлэх (Чингэлтэй, Сонгинохайрхан)	1
57		Шинэ суурьшлын бүсэд инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийг үргэлжлүүлэх (шугам сүлжээ)	1
58			“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийг үргэлжлүүлэх (инженерийн байгууламж)	1
59	Авлигын үзүүлэлтийг сайжруулна.	Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх	0
60	Хүний эрхийн зөрчлийг бууруулна.	Иргэний эрхийн тэгш байдлыг хангана.	Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын сургуулийн барилга (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1
61	Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	Хил орчмын аюулгүй байдлыг сайжруулна.	Хилийн боомтын аюулгүй байдлыг хангаж, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системд холбох	0
62	Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.	Шүүхийн шинжилгээний дүгнэлтэд ирсэн гомдлыг бууруулна.	Бүсийн шүүх шинжилгээний төв байгуулах (Дорнод, Ховд, Дархан)	0
63			Шинэ төрлийн шинжилгээ хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, программ хангамж авах	1
Нийт				36

Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө (<https://legalinfo.mn/mn/detail?lawid=16759684448041&showType=1>),

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл (<https://d.parliament.mn/tusul/c559f76b-1884-44ec-b34e-ee9afbbb2fcc>)

Боловсруулсан: С.Баттулга
Эдийн засагч



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn